



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2024. 08. 08 № 448  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Дарьганга СУМЫН  
СОНГУУЛИЙН ХОРОО-Д

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, ТЕЗ-ийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Ардын намын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр ( ..... хуудас)-ийг хавсаргав.


ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА



СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН 2024 ОНЫ ОРОН  
НУТГИЙН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН МӨРИЙН  
ХӨТӨЛБӨР



Сүхбаатар аймгийн Монгол Ардын нам 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиар Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн реформ, МАН-ын 2024 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр, “Аймгийн хөгжлийн зорилт 2020-2028” хөгжлийн бодлогын баримт бичиг батлах тухай, иргэд, олон нийтийн саналд үндэслэн Дарьганга сумын МАН-ын хорооны 2024 оны орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө тодорхойлж байна.

Мөрийн хөтөлбөрөө боловсруулахдаа хүний хөгжил, эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах, орон нутгийг хөгжүүлэх, төрийн бодлогын залгамж чанарыг хадгалахад онцгой анхаарч, дараах таван бүлэг асуудлын хүрээнд 13 зорилт дэвшүүлж, 86 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тодорхойллоо.

## НЭГ.ХҮНИЙ ХӨГЖИЛ

### 1.1. Эрүүл мэнд

**Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, орчин үеийн оношлогоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж дундаж наслалтыг уртасгана.**

1.1.1 “Элэг бүтэн Монгол”, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөрийн хүрээнд хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношлогоо, шинжилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

1.1.1.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, зөв дадал хэвшлийг бий болгоход чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах

1.1.1.2 “Хавдрын эсрэг хамтдаа” арга хэмжээг жил бүр зохион байгуулах

1.1.1.3 Элэг бүтэн Монгол хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

1.1.1.4 Эрэгтэйчүүдийн өвчлөл, нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлийг судалж, Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх

1.1.1.5 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлгийг оновчтой, эрсдэлд суурилсан байдлаар тасралтгүй үргэлжлүүлж хүйсийн ялгаатай байдлыг багасгах бодлого хэрэгжүүлнэ.

1.1.1.6 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох өвчнөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог


бэхжүүлнэ.

**1.1.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.**

1.1.2.1 Нарийн мэргэжлийн эмчтэй болно. /шүдний эмч/

1.1.2.2 Явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг жил бүр сумандаа авч иргэдийг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах

1.1.2.3 Хүүхдийн шүдний өвчнийг багасгаж, хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлэн эмчлэх



**1.2. Биеийн тамир, спорт**

***Иргэдийг спортын олон төрлөөр хичээллэх боломжийг бүрдүүлж, амжилтыг ахиулна.***

**1.2.1 Үндэсний спортыг хөгжүүлж, өв уламжлалаар дамжуулан хүүхэд залуусыг төлөвшүүлнэ.**

1.2.1.1 Үндэсний болон Оюуны спортын наадмуудыг орон нутагтаа зохион байгуулж, Улс, аймгийн чанартай тэмцээн уралдаанд оролцох.

1.2.1.2 Сумын нэрийг гаргаж улс бүс, тив дэлхийд өрсөлдөж амжилт гаргаж буй тамирчдаа урамшуулан дэмжих тогтолцоогоо үргэлжлүүлнэ.

1.2.1.3 Нийтийн спортын орчин, нөхцөлийг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх

1.2.1.4 Идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэгсдийн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэхжүүлэх

1.2.1.5 Багийн спортыг хөгжүүлнэ /гар бөмбөг, сагсан бөмбөг, хөл бөмбөг/

1.2.1.6 Залуус чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх Залуус хөгжлийн төвтэй болох

**1.3. Боловсрол**

***Боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж, хүүхдэд ээлтэй зарчим баримталж, насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлнэ.***

**1.3.1 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломжийг нэмэгдүүлж, чанартай боловсрол олгоно.**

1.3.1.1. Цэцэрлэгийн хүүхдүүдийн сургалтын хэрэглэгдэхүүн, гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийн "Ном, тоглоомын багц"-ыг жил бүр нас, насаар нь үе шаттай шинэчлэх

**1.3.2 ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн багш нарын ур чадварыг дээшлүүлнэ.**

1.3.2.1 Багшийн ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, мэргэжлийн нэр хүндийг өсгөхийн зэрэгцээ хариуцлага, ур чадварыг дээшлүүлэх

1.3.2.2 ЕБС-ийг мэргэжлийн багш, мэргэжилтнээр бүрэн хангах /англи хэл, түүх, номын санч г.м/

1.3.2.3 Багшийн хөгжилд дэмжлэг үзүүлэх сургалт арга зүйн байгууллагын чадавхыг




дээшлүүлэх

### **1.3.3 Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.**

1.3.3.1 Төрийн албан хаагчдад монгол бичгийн сургалт явуулж албан бичиг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангуулах

1.3.3.2 Албан байгууллага, аж ахуйн нэгж болон нийтийн эзэмшлийн талбай, гудамжны хаягийг монгол бичгээр бичих



### **1.4. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил**

*Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соён гэгээрүүлж, гэр бүлийн боловсролыг дээшлүүлнэ.*

#### **1.4.1 Гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх сургалт нөлөөллийн ажлын хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

1.4.1.1 "Гэр бүл, хүүхдэд ээлтэй байгууллага" шалгаруулах болзолт уралдаан зохион байгуулах.

1.4.1.2 Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд, Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтанд хамруулах

1.4.1.3 Зорилтот өрхийн хөгжлийг дэмжих "Гэр" болон "Мал" төсөл хэрэгжүүлэх //

1.4.1.4 Залуучуудад гэр бүл төлөвлөлтийн талаар сургалт зохион байгуулах

#### **1.4.2 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин, нөхцлийг бүрдүүлнэ.**

1.4.2.1 Ахмадын өргөөг шинээр барих, хөгжлийн төв байгуулах, зөвлөх үйлчилгээ авах

1.4.2.2 Ахмадуудыг урлаг, спортын наадамд оролцоход дэмжлэг үзүүлэх

1.4.2.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоог хангаж, нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаа болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

#### **1.4.3 Залуучуудын хөгжлийг дэмжинэ.**

1.4.3.1 "Гэр бүл – залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

1.4.3.2 "Нутгийн Залуучууд" хэлэлцүүлэг зохион байгуулах

1.4.3.3 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлэх

### **1.5. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал**

*Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, өрхийн амьжиргааны түвшнийг дээшлүүлнэ.*

#### **1.5.1 Хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.**

1.5.1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах

1.5.1.2 Гарааны бизнес буюу старт-аппыг дэмжиж, хөгжүүлэн ажлын байрыг бий болгох

1.5.1.3 Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх сургалтад залуучуудыг

хамруулах

- 1.5.1.4 “Ажилтай төгсөгч” шинэ төгсөгчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх
- 1.5.1.5 Салбар хоорондын хамтын ажиллагааг өрнүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- 1.5.1.6 Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд, бичил бизнесийн дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тэлэх бодлого баримталж, шударга, ил тод олгох зарчмыг баримтлан хэрэгжүүлэх
- 1.5.2 **Өрхийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх арга хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.**
- 1.5.2.1 Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах
- 1.5.2.2 Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлэх

## 1.6. Үндэсний бахархал, өв соёл

***Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.***

1.6.1 **Үндэсний үнэт зүйлсийг хадгалж хамгаалан хойч үедээ өвлүүлэн уламжилна.**

1.6.1.1 Түүх соёлын биет болон биет бус өвийн хамгаалалтыг сайжруулах

1.6.1.2 Орон нутаг судлах танхимыг Дарьганга судлал болгон өргөтгөх

1.6.2 **Номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

1.6.2.1 Нийтийн болон сургуулийн номын сангийн номын фондыг орчин үеийн номоор баяжилт хийх, стандартын болгон тохижуулах

## ХОЁР.ЭДИЙН ЗАСАГ

### 2.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

***Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өргөжүүлэн, малын эрүүл мэндийг хамгаалж, малын ашиг шимийг дээшлүүлнэ.***

2.1.1 **Бэлчээр, хүнсний ногоо эрхлэлтийг дэмжинэ.**

2.1.1.1. Орон нутгийн түвшинд бэлчээрийн даац сэргэх чадавхийг нэмэгдүүлэх 1 наст тэжээлийн ургамлыг 5 га газарт тариалах

2.1.1.2. Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, хөнгөлөлтэй зээл тусламж үзүүлэх

2.1.1.3. Бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг зохион байгуулах

2.1.1.4. Малчдын бүлэг хоршоо байгуулж, “Малчдын дундын сан”-г баг бүрт байгуулах,



тэдний хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийг тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх

- 2.1.1.5. Зудад өртсөн малчдыг малжуулах хөтөлбөрийг эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлж, малын тоо бус чанарыг чухалчлах
- 2.1.1.6. Зудын эрсдэлийг даван туулах "МАЛЖУУЛАХ" төсөл хэрэгжүүлэх
- 2.1.1.7. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлэх

## **2.1.2 Малын гоц халдварт, халдварт, өвчнөөс урьдчилан сэргийлнэ.**

- 2.1.2.1 Мал сүргийг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд бүрэн хамруулах
- 2.1.2.2 Шимэгчлэх өвчний халдварлалтыг бууруулах
- 2.1.2.3 Өвөлжөө, хаваржааны газрыг эрүүл ахуйг сайжруулах хүрээнд ариутгал, халдваргүйтгэл хийх

## **2.1.3 Бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана.**

- 2.1.3.1 Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгоход дэмжлэг үзүүлэх
- 2.1.3.2 Сүхбаатар хөгжил арга хэмжээний хүрээнд "Эрүүл хүнс", "Алтан намар", "Сүхбаатарт үйлдвэрлэв", "Дарьгангад үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдаанд жил бүр оролцох
- 2.1.3.3 "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг үндэсний хэмжээнд өрнүүлж, хоршоолохыг дэмжих
- 2.1.3.4 Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах бодлого боловсруулах бодлого баримталж, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд хувийн хэвшилтэй хамтран ажиллах
- 2.1.3.5 Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулж уургийн агууламж өндөр түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг дэмжих
- 2.1.3.6 Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар малчдын орлогын тогтвортой нэмэгдүүлэх

## **2.2. Аялал жуулчлал**

### **2.2.1 Орон нутагт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлнэ.**

- 2.2.1.1 Монгол өв соёлыг хадгалах зорилгоор монгол наадгай, тэмцээн уралдаануудыг зохион байгуулах
- 2.2.1.2 Ганга нуур орчим аялал жуулчлалын бүс байгуулж жил бүр "Хунгийн баяр" арга хэмжээг улсын хэмжээний арга хэмжээ болгох
- 2.2.1.3 Алтан овоо, Шилийн богд, Ганга нуур гэсэн маршрутад аялал жуулчлалын отго байгуулах, хөтөч бэлтгэх

## **ГУРАВ. ЗАСАГЛАЛ**

**"Иргэн төвтэй хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, ногоон технологи бүхий сайн засаглалыг хөгжүүлнэ.**

- 3.1.1. Мэдээллийн нэгдсэн цахим программыг нэвтрүүлнэ.

3.1.1.1. Сумын вэб сайтыг хөгжүүлэн, төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох

3.1.1.2. Архивд хадгалагдах баримтуудыг цахимд шилжүүлэх ажлыг зохион байгуулах, техник тоног төхөөрөмжөөр хангах

**3.1.2. Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.**

3.1.2.1 Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, орон сууцны нөхцлийг сайжруулахад анхаарч төр хувийн хэшдийн хамтын ажиллагааг хангаж бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.

3.1.2.2 Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, чадавхижуулах, сургалт сурталчилгаанд тогтмол хамруулах

**3.2. Амар тайван, аюулгүй нийгэм**

***Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.***

**3.2.1 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог хангана.**

3.2.1.1 Сумыг бүрэн камержуулах ажлыг зохион байгуулна.

3.2.1.2 Засмал замыг дуусгаж өргөтгөх, замын тэмдэг, тэмдэглэгээг засаж, нэмэгдүүлэх

3.2.1.3 Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй хамтран тогтмол зохион байгуулах.

**3.2.2 Мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.**

3.2.2.1 Малчдын бүлгийн хяналтыг сайжруулах ГХУСА-д идэвхитэй оролцсон бүлгийн ахлагч нарыг урамшуулах тогтолцоонд шилжих, зардлыг төсөвт тусгуулах

**ДӨВӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ**

**4.1. Ногоон хөгжил**

***Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулна.***

**4.1.1. Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийн талаарх боловсролыг дээшлүүлнэ.**

4.1.1.1. Иргэдэд байгаль хамгаалах, ногоон хөгжлийн боловсрол олгох сургалт, арга хэмжээ зохион байгуулах

4.1.1.2. ЕБС, цэцэрлэгийн хүүхдүүдэд байгаль дэлхийгээ хамгаалах талаар сургалтыг тогтмол зохион байгуулах

4.1.1.3. Тэр бум мод хөтөлбөрийг дэмжиж ажиллах

**4.1.2. Ховордсон биологийн төрөл зүйлийн нөөцийг хамгаалж, сэргээн нутагшуулна.**

4.1.2.1. Монгол тарвага сэргээн нутагшуулах, хамгаалах ажлыг үргэлжлүүлэн хийх




4.1.2.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр нөхөрлөл байгуулах, хамтарч ажиллах

4.1.3. Усны бохирдол, хомсдолоос хамгаална.

4.1.3.1. Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулна.

4.1.4. Орчны бохирдлыг бууруулна.

4.1.4.1. Айл өрхийн эко шийдлээр хийгдсэн нүхэн жорлонгийн тоог нэмэгдүүлэх



## ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

**5.1. ДАРЬГАНГА суманд амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, сум болгон хөгжүүлнэ.**

**5.1.1. Иргэдийг амьдрахад таатай орчин бүрдүүлнэ.**

5.1.1.1. Гудамж талбайг тэгшилж зүлэгжүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

5.1.1.2. Залуучуудын цэцэрлэгт хүрээлэнтэй болох

5.1.1.3. Сумын төвийн хатуу хучилттай авто зам, агаарын шугамыг өргөтгөн шинэчилнэ.

5.1.1.4. Соёлын төвийн их засварын ажлыг хийж гүйцэтгэх

5.1.1.5. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрыг шинээр барих ажлыг эхлүүлнэ.

5.1.1.6. Сумын нийт иргэдийн дунд хүнсний ногоо тариалалтыг нэмэгдүүлж өрх бүрийг хүлэмжтэй болгох

5.1.1.7. БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар адуучин С.Шарбандийн цэцэрлэгт хүрээлэнг өргөтгөх, тохижуулах

5.1.1.8. Сумын төвд гэрэлт гудамжийг нэмэгдүүлэх

5.1.1.9. Сумын төвд инженерийн шугам сүлжээ шинээр ашиглалтад орох тул айл өрх, албан газар, аж ахуйн нэгжийг шугамд холбож, хүмүүсийн амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх

